

## ТҮҮХ, ЭДИЙН ЗАСАГ

**БНХАУ ДАХЬ ХЯТАД БУС АРД ТҮМНИИ  
ХУВЬ ЗАЯА  
(Орчуулга)**

Зөвлөлтийн нэрт дорнодахинч Т. Р. Рахимовын бичсэн «БНХАУ дахь хятад биш ард түмний хувь заяа» («Рахимов Т. Р, «Судьбы неханьских народов в КНР». Москва. Мысль. 1981. 157 с.») гэдэг ном саяхан «Маойзм хүп төрөлхтөнд занал учруулж байна» гэдэг цувралаар хэвлэгдэн гарлаа. Энэ товхимолд БНХАУ-ын бүрэлдэхүүнд багтдаг хятад биш ард түмний түүх, эдийн засаг, соёл хийгээд олон үндэстний хятад улс бүрэлдэн тогтсоны онцлог, маогийнхнаас тэдний түүхийг хэрхэн гуйвуулж байгааг илчлэн үзүүлжээ.

Үндэстний асуудлыг «шийдвэрлэх» маоист онол, практикийг задлан шинжилж уг асуудлаар хятадын удирдагчдын бодлого социализмын эсрэг, их хан үндэстний үндсэрхэг дээрэнгүй үзлээр илэрч байгааг үзүүлэхийн зэрэгцээ тэд хятад биш үндэстний эдийн засаг, соёлыг хөгжүүлэх явдлыг үндэстний районуудыг цэрэгжүүлэхээр сольж байгааг илчлэн харуулсан байна. Уг номноос хэсэгчлэн орчуулж дор нийтлэв.

БНХАУ бол олон үндэстэнтэй том улс юм. Түүний нутаг дэвсгэрт 50 гаруй янз бүрийн ястан үндэстэн оршин сууж байна. Тэдний дийлэнхи олонхи хятадууд билээ. Тэд өөрсдийгөө хятадууд (Чжунго жэнь) «Дундат улсын иргэн», «Хан үндэстэн» буюу «Хан хүн» гэдэг. Тэднийг ном зохиолд хятад оронд оршин суугаа бусад ард түмнээс ялгахын тулд «ханчууд» гэдэг нэр томъёог хэрэглэнэ. Ханчууд нь тус орны өнцөг булан бүрт таран суудаг боловч Төв хятад болон Зүүн хойт районоор хамгийн нягт шигүү оршин сууна. 1978 оны албан ёсны мэдээгээр хятадын хүн ам 958 сая, түйний дотор ханчууд 900 гаруй сая буюу хүн амын амын 94 хувийг эзэлж байна.

БНХАУ-д хан үндэстэнээс гадна 56 сая<sup>1</sup> хан бус буюу хятад биш ястан үндэстэнүүд оршин суудаг бөгөөд тэднийг хятадын суртал нэвтрүүлэгт их хан үндэстний дээрэнгүй үзлийн үүднээс «үндэстний цөөнх» буюу «шаошу минь цзу» гэж нэрлэдэг. Бөөнөөрөө оршин суух тодорхой нутаг дэвсгэргүй, тархай бутархай сууж байгаа буюу өөр үндэстний нутаг дэвсгэр дээр амьдарч буй хэсэг бүлэг хүмүүсийг «үндэстний цөөнх» гэж ерөнхийд нь нэрлэдэг билээ. Гэтэл хятадад амьдарч байгаа хятад биш бүх ард түмнийг «үндэстний цөөнх» гэж Маоистууд нэрлэж байгаа нь буруу юм. Маоистууд үндэстний цөөнх гэж үздэг уйгурууд нь БНХАУ байгуулагдах үед Сиизьяны хүн амын 75-80 хувийг, төвдүүд төвд оронд оршиж суугчдын 95 хувийг эзэлж мөн Өвөр Монголд монголчууд нэгэн адил уугуул үндсэн хүн ам болж байлаа. Ийм учраас тэднийг үндэстний

«Жэньминь жибао» 1979. IX. 25.

цөөнх гэж болохгүй билээ. Тоог нь зориуд багасгаж гаргасан Хятадын албан ёсны мэдээ баримтаас үзэхэд ч гэсэн хятад биш ард түмний дотроос томоохонд тоологдох Жуан 12 сая орчим, хотон 6,5 сая, уйгур 5,5 сая И 4,8 сая, төвд 3,5 сая, монгол 2,6 сая орчим, манж 2,6 сая орчим, солонгос 1,7 сая орчим, буй 1,7 сая<sup>2</sup> орчим хүнтэй байгаа юм.

Одоо БНХАУ-ын хэвлэлд нийтэлж байгаа албан ёсны мэдээнд гарч байгаа хятад биш ард түмний хүн амын тоо зөрөөтэй, найдваргүй тоо гэдгийг тэмдэглэвэл зохино.

Их хан үндэстний дээрэнгүй үндсэрхэх үзлийн үүднээс ийм албан мэдээнд хятад биш ард түмний тоог албаар зориут багасгаж тэдний эзэлж байгаа хувийн жин, гүйцэтгэх үүргийг бууруулах гэж оролддог болохоор хятад биш үндэстэн ястны тоо урьд өмнө нийтэлсэн тооноосоо голдуу бага байна.

Хятад биш ард түмэн нь БНХАУ-ын нутаг дэвсгэрийн 60 хувийг эзэлж голдуу зах хязгаарын нутгаар оршин суудаг юм. Тэдний оршин суудаг үндсэн нутаг нь Өмнөт ба Баруун өмнөд хятад (Юньнань, Гуандун, Сычуань, Гуйчжоу муж, Гуанси чжуан, Төвдийн автономит район), Баруун хойт, хятад (Өвөр Монгол, Синьзян-уйгур, Нинся Хуэйгийн автономит районууд, Ганьсу, Хөх нуур мужууд) билээ. Зүүн хойт хятадад хятад биш хэд хэдэн ястан үндэстэн мөн оршин суудаг юм. Хятад биш оршин суугчдын хамгийн олон угсаатан байдаг нутаг нь өмнөт ба баруун өмнөт хятад ялангуяа Гуандун муж, (Хайнань арал) Гуйчжоу, Сычуань, Юньнань, Гуанси-Чжуаны автономит район билээ. Энд чжуан, төвд буй, мяо, тай, хан, лаху, лису, ли, яо, хуэй гэх мэт олон ястан үндэстэн байна.

Дээр үеэс эдгээр ястан үндэстний оршин сууж байсан энэ нутгийг хятадууд эзэмшин эдлэх болсноос одоо Юньнань, Гуйчжоу хоёр мужийн хүн амын гуравны хоёр нь, Гуанси-Чжуаны автономит районд 60 гаруй хувь нь хятадууд байна.

Хятадын хойт, баруун хойт хэсэгт уйгур, монгол, казах, киргиз гэх мэт хятад биш ард түмэн нутаглаж, хятадын зүүн хойт хэсэгт манж, орчоон, эвэнк, гэх мэт ястнууд оршин сууж байна. Хятадын зарим нэг мужид хятад биш ард түмэн хүн амын тооны ихэнхи хувийг эзэлж байв. Жишээ нь Синьзянд БНХАУ-ыг байгуулагдах үе хүртэл хятад биш хүмүүс 94 хувийг, хятадууд дөнгөж 6 хувийг эзэлж төвдийн ихэнхи нутагт хятадууд огт байхгүй байсан юм.

БНХАУ-ын хятад биш ард түмний ихэнхи хувь нь өөрсдийн үндэсний төрөлх хэлээр ярьж байна.

Одоогийн байдлаар 70 гаруй үндэстний хэл байна. Эд нарын ихэнхи нь хятад хэлнээс их ялгаатай юм. Жишээ нь уйгур, казах, киргиз гэх мэт түрэг хэл, монгол, дунсян гэх мэт монгол манж сибин, нанай зэрэг тунгус-манж бүлгийн хэл байна. БНХАУ-ын хятад биш үндэстнүүдийн зарим нь өөрийн бичиг үсэгтэй, утга соёлын баялаг уламжлалтай билээ.

Төвд бичиг VII зууны үед зохиогдсон, монгол, манж бичгийн эх үүсвэр болсон уйгур бичгийн цагаан толгой X зууны сүүлээр гарчээ. Энэхүү уйгур цагаан толгой бол сирий-арамейн цагаан толгойн бүлэгт ордог.

Хятадууд одоо хүртэл дүрсийн бичиг хэрэглэж байхад хятад биш ард түмэн цагаан толгойтой бичиг хэрэглэж байгаа юм. Төвд, Юньнань мужийн Тай үндэстэн нь үет хэлбэрийн цагаан толгой хэрэглэж байна. Гэвч Хятадад амьдарч байгаа хятад биш ард түмний дийлэнх олонхи нь өнөө хүртэл бичиггүй байна.

Хятад биш ард түмэн нь түүх, соёл, угсаатны зүйн талаар хятадуудаас ялгаатай. Эд нар үндэстний өвөрмөц байдал үндэснийхээ уламжлалыг олон зуун жил хадгалсан түүхтэй байна.

Хятадын доторхи хятад биш ард түмний дотроос хүн амын тоогоор хамгийн олон нь чжуан нар билээ. 12 сая чжуан үндэстэний ихэнхи хэсэг нь (11 сая хүн) Гуанси-чжуаны автономит районд сууж байна.<sup>3</sup> Чжуан нар тус районы газар нутгийн 60 хувь дээр оршин сууж байна.<sup>4</sup>

Хятадын түүхийн X-XIII зууны он дарааллын бичигт өгүүлснээр чжуан нар өндөр хөгжсөн эдийн засаг, соёлтой, үндэстний тусгаар тогтнолын, төлөө тэмцэж байжээ. XI зуунд чжуан нар наньтяньго (өмнөд тэнгэрийн улс) гэдэг үндэстний биеэ даасан улс байгуулсан юм. Юань улс (XIII-XIV), Мин (XIV-XVII) улсын үед Чуан нар үндэстний эрх чөлөөний төлөө тэмцэл явуулж байжээ.

Манж Чин улсын дарлалын эсрэг явагдсан Тайпины бослогод чжуаны ард түмэн идэвхтэй оролцжээ. 1920-40-өөд оны хувьсгалт тэмцэлд Гуанси мужийн хятад биш ард түмэн өргөн хэмжээгээр оролцсон юм. Энэ нь 1949 оны 10-р сарын хувьсгалын ялалт нь зөвхөн хан үндэстний ялалт биш гэдгийг харуулж байна.

БНХАУ-ын хятад биш томоохон ард түмний тоонд уйгурууд орно. Уйгур ард түмний олон зуун жилийн түүх нь Дундад Ази, Казахстаны ард түмний түүхтэй холбоотой юм. Уйгур нь хэл соёлоор узбекуудтай ойролцоо ажээ.

Уйгурын бичгийг монгол, манж нар авч хэрэглэсэн юм. Уйгуруудын эх орон бол Дорнод Туркестан билээ. Хятад XVIII зуунд Дорнод Туркестантай Зүүнгарыг нийлүүлээд Синьзиян гэдэг нэр өгчээ.

1955 оноос Синьзиян-Уйгурын автономит район (СУАР) гэж албан ёсоор нэрлэдэг болсон юм.

Уйгурууд бол Синь зян уйгурын автономит районы уугуул үндсэн ард түмэн юм. 1949 онд БНХАУ байгуулахад энэ нутгийн ард түмний 75-80 хувийг уйгурууд эзэлж байлаа. Уйгурууд ЗХУ-д оршин суудаг, Тэдгээр нь голдуу Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Казах, Киргиз, Узбек гурван улсын нутагт байдгаас гадна зөвлөлт Туркестаны нутагт цөөн тоотой оршин сууж байна.

1970 оны хүн амын тооллогоор ЗХУ-д 173 мянган уйгурууд бий. 1959 оноос хойш БНХАУ-ын СУАР-аас шилжин ирсэн олон тооны уйгарууд зөвлөлтийн нутагт суурьших болсноос тэдний тоо нэмэгджээ.

Анх түрэг хэл дээр бичигдсэн лалын яруу найргийн сургалтын ухааны анхны бүтээл «Кутэдгу билик» (жаргалын тухай ухаан)-ыг уйгар Балгасуны Юсуфо Хас Хажиб 1069 оноос 1070 он хүртэл хугацаанд бичжээ. Уйгур хэл дээр бичигдсэн том бүтээл «Диван лугат ат түрэг» (түрэг хэлүүдийн толь бичгийг) XI зууны агуу их эрдэмтэн Кашгарын Махмуд бичжээ. Энэ бүтээлд түрэг ард түмнүүдийн угсаатны зүй болон газар зүй болон газарзүйн талаар арвин баялаг материалуудыг оруулсан байна.<sup>5</sup>

Уйгурууд олон удаа бие даасан улсыг байгуулж байжээ. Жишээ нь Орхон голын хөндийн улс байгуулан зуу шахам жил (745-840) оршин тогтнож байв. X-XIV зуун хүртэл Тэнгэр уулын дэргэд уйгарын улс 500 гаруй жил, оршин тогтнож байжээ. Энэ улс тэр үеийн Төв Азийн хөгжилтэй баян орны тоонд ордог байжээ. Уйгарууд эртний түрэг айм-

<sup>3</sup>Москалев. А. А. Гуанси-Чжуанский и Нинся-Хуэйский автономные районы КНР. М., 1979., с 137.

<sup>4</sup>Мөн ном. 24—25-р тал.

<sup>5</sup>Малов. С. Е. Памятники древнетюркской письменности. М. М. Л: 1956 Хамраев М. К. Веков неумирающее слово. Алма-Ата. 1969.

гийн тоонд ордог гэж оросын нэрт эрдэмтэн В. В. Радлов бичжээ. Уйгур бол 932 оноос 1165 он хүртэл Төв Азид Караханидийн улсыг байгуулсан гол ард түмэн юм. Энэ үеийн уйгурын Кашгар, Хотан, Яркенд гэх мэт хот өндөр хөгжсөн уран барилгатай том төвүүд байжээ. Кашгар хот Тимуридах (1370-1507)-ын үед болон түүний дараах жилүүдэд дорнодахины лалын соёлын том төв болж байлаа.

Олон зуун жилийн туршид уйгур ард түмэн өөрсдийн эрх чөлөөний төлөө баатарлаг тэмцэл явуулж ирэв. Дорнод Туркестан 1864 оны бослогын дараа уйгурын Иэттишар (Долоон хотын улс) гэдэг улс байгуулж 1877 он хүртэл тогтнож байв.

Уйгуруудын хамгийн сүүлийн биеэ даасан улс бол 1944 онд байгуулагдсан Бүгд Найрамдах Дорнод Туркестан улс юм. Энэ улс Синзяны ах дүү ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний үр дүнд байгуулагджээ. Энэ хөдөлгөөн 1949 оны 10-р сард хятадын ардын чөлөөлөх арми Оинь зяныг Гоминьданаас чөлөөлөхөд маш их нөлөө үзүүлсэн юм.

Төв Азийн эртний ард түмний нэг нь Төвд ард түмэн юм. Одоогийн төвдийн автономит район нь 1,2 сая кв км нутаг дэвсгэртэй юм. Энэ нутаг дэвсгэр Их Британи Ирланд, Франц, Дани, Голланд, Бельги зэрэг улсуудтай тэнцэнэ. 1953 оны хүн амын албан ёсны тооллогоор БНХАУ-ын нутаг дээр 3 сая төвд байсан юм. Гэхдээ төвд үндэстэний тоо 7-10 сая хүрнэ гэж төвдүүд өөрсдөө үздэг байна. Балба, Бутан, Энэтхэг зэрэг оронд олон тооны Төвд амьдарч байна.<sup>6</sup> VII-IX зуун хүртэл хугацаанд оршин байсан Төвдийн анхны улс нь тэр үеийн Төв Азийн хүчтэй орны нэг нь байжээ. Төвд ард түмэн хятадтай байлдахдаа олон удаа амжилтанд хүрч байв. 763 онд төвдийн цэрэг Тан улсын Чаньянь хотыг эзлэн авчээ. VII-IX зуун хүртэлх хугацаанд хятад төвдийн хооронд тэгш эрхтэй хоёр улсын харилцаа явуулж байснаас биш нэг нь нөгөөгөө ноёлох харилцаа явуулж байсангүй.

XIII зууны сүүлчээр төвд нь хятадтай адилхан Монголын Юань улсад харьяалагдаж байв. XIV зууны эхээр төвд дахин биеэ даасан улс болсон билээ. Төвд нь 1792 онд Манж Чин улсын харьяанд орсон боловч өөрийн зэвсэгт хүчинтэй, үндэсний мөнгөтэй, хууль цааз шүүхтэй байсан юм. Манж Чин улс мөхөсний дараа Төвд дахин биеэ даасан улс болж сэргэжээ. Гоминьданы зэвсэгт хүчнийг Төвд амжилттай эсэргүүцсэн юм. 1949 онд Төвдийн засгийн газар Лхасаас Гоминьданы төлөөлөгчдийг хөөсөн юм.

Төвд ард түмэн соёлын баялаг уламжлалтай юм. VII зууны эхээр төвд бичиг зохиогдсон. Дуньхуаны эртний номын хадгаламжинд VIII-X зууны үеийн төвд хэл дээр бичигдсэн ном байгаа юм.

Төвд эрдэмтэд төвд, хятад, энэтхэг зэрэг олон орны түүх, газарзүй, ёс зүй, гүн ухаан, анагаах ухааны талаар ном бичиж байжээ.<sup>7</sup> Түүний зарим нь европ хэл дээр орчуулагджээ. Төвд ард түмэн өөрийн өвөрмөц уран барилгатай.

Төвд орон олон зуун жилийн турш Ази тивийн соёл, шашны мөргөлийн нэг төв болж байв. VII зуунд Төвд оронд буддийн шашин дэлгэрч сүүлд нь шарын шашны хэлбэрээр улсын шашин болсон тэр цагаас хойш Лхас нь шарын шашны төв болсон юм.

XIII зууны үед шарын шашны гол сургаал Ганжуур Данжуурын 300 ботыг бичиж дуусгажээ. Энэ зохиолд дан шашны зүйл ороогүй харин уран зохиол, гүн ухаан, тооны ухааны бүтээлүүд орсон байна. Төвдөд

<sup>6</sup>Богословский В. А. Тибетский район КНР (1949—1976) М. 1978, с 6, 182.

<sup>7</sup>Великодержавная политика маоистов в национальных районах КНР. М., 1975. с 104.

энэтхэгийн уран зохиолын нэртэй бүтээл «Рамааяна», «Панчатантра» нь өргөн хэмжээгээр дэлгэрчээ. Ийм учраас Төвдөд энэтхэгийн соёлын нөлөө хятадын соёлын нөлөөнөөс илүү байжээ.

Хятад биш том ард түмний тоонд ордог (6,5 сая хүнтэй) Хуэй нар буюу дунган үндэстэн голдуу баруун хойт хятадын Нинся-Хуэйгийн автономит районд (1,2 сая хүнтэй), Ганьсу мужид (1 сая), Хөх нуур мужид (300 мян), Синьзянд (150 мян), Хэнань-д (400 мян), Хэбэйд (400 мян), Шаньдунд (300 мян), Юньнаньд (200 мян) тус тус оршин сууж байна. Бээжинд 100 мянган хуэй амьдарч байна. XIX зууны 60-70-аад онд баруун хойт хятадад, Манжийг эсэргүүцсэн «Дунганы бослого» гарчээ.

БНХАУ-ын нутаг дээр амьдарч байгаа монголчууд нь олон зуун жилийн баялаг түүхтэй, өвөрмөц соёлтой, түүний эртний түүх, соёлын дурсгалт зүйл нь одоо хүртэл байгаа юм. Хятад биш ард түмний нутгийг хятадууд хүчээр эзлэн авч колоничлон ноёрхож байв. Тэднийг устгаж, уусган хятадчилж, тариалангийн газрыг хуразн авч байжээ. Энэхүү хурааж авсан газар дээрээ нүүдэллэн ирсэн хятадуудыг суулгаж байв. Бас заримдаа гэмт хэрэг үйлдсэн хятадуудыг ч нүүлгэн суулгаж байлаа. Хятад биш ард түмний газар нутгийн ихэнхийг хятад түшмэд, худалдаачид, цэргийн эрхтнүүд эзэмшиж байсан юм. Жишээлбэл Өвөр Монголчуудыг малтай нь хамт цаг уурын хахир хатуу улиралтай хойт хэсэг рүү нь хөөж байжээ. Өвөр Монголд 1902 оноос 1908 он хүртлэх хугаанаанд хятадууд 7 сая му бэлчээр нутгийг эзэлж авчээ.

Хятадууд их хан үндэстний ноёрхлоо тогтоохын тулд хятад биш үндэстнүүдийг хооронд нь мөргөлдүүлж байв. Ийм мөргөлдөөн Синь зян, Өвөр Монголд гарч байжээ. Хятад биш ард түмэнд эмнэлгийн тусламж огт байхгүй, харин тэдний оршин суугаа газарт тахал өвчин өргөн хэмжээгээр дэлгэрч олон зуун мянган хүн нас барж байжээ. Жишээ нь Синьзянд хүүхдийн 80 хувь<sup>8</sup> нь ойдоо хүрэлгүй нас бардаг байв БНХАУ байгуулагдахын өмнө хятад биш ард түмний нийгэм эдийн засгийн байдал нь иймэрхүү байлаа.

Хятадын түүх нь олон үндэстний улс учраас хэд хэдэн онцлогтой. Нэг гол зүйл нь эзэн хаант хятадын мянган жилийн түүхэнд (Тан улс 907 онд мөхсөнөөс Манж Чин улсын мөхсөн 1911 он хүртэл) 300 жил хятад хаадын засаг тогтож харин бусад 700 жил харь орны хаадын ноёрхолд байлаа. Заримдаа хятадын баруун хойт хэсэг (Кидан, Зүрчид 916-1264) эсвэл хятадыг бүхэлд нь эзэлж байсан (Монголын Юан улс 1280-1368), Манж Чин улс (1644-1911) билээ. Манж Чин улсыг унагасан Синьхайн хувьсгалын дараах 1949 он хүртэл хятадын нутаг дээр иргэний дайн явагдаж японд эзлэгдэж байсан (1931-1945)<sup>9</sup>

Хятадын олон үндэстний улсын бас нэг онцлог нь хятадын одоогийн хил хязгаар нь XVIII зууны II дахь хагасын үед тогтжээ. Үүнээс өмнө Төвд, Синьцзян, Өвөр Монгол гэх мэт биеэ даасан улс байлаа. Чин улсын хаадын зэвсэгт хүчээр олон үндэстний улс байгуулахдаа олон зуун мянган монгол, төвд уйгар гэх мэт хятад биш ард түмнийг устгасан юм. Одоогийн Синьзянь-Уйгурын автономит районы нутагт багтаж байсан Зүүнгар, Дорнод Туркестаныг Чин улсын хаадууд 1757-1759 онуудад эзлэн авчээ. Энэ түрэмгийллийн үед Зүүнгарын 1 сая гаруй хүнийг

<sup>8</sup>Рахимов. Т. Национализм и шовинизм-основа политики группы Мао Зэдуна. М. 1968., с. 58-59.

<sup>9</sup>Сладковский М. И. Основные аспекты Маоистской фальсификации историй. В: сб: Актуальные проблемы борьбы с Маоистскими фальсификациями в области историй. Материалы конференций. М. 1979. с 5—6.

устгаж<sup>10</sup> нийт хүн амыг нь бараг хүйс тэмтэрсэн юм. Зүүнгарын хотуудыг сөнөөж, тариалангийн талбайг сүйтгэжээ.

Хятад биш ард түмэн хятадын их гүрний дээрэнгүй бодлогыг эсэргүүцэж зэвсэгт тэмцэл явуулж байв. Үүний жишээ болгож 1864 оны Синьзяны уйгурууд болон бусад ард түмний бослого (энэ бослогын дүнд байгуулагдсан Иэттишар улс 1877 он хүртэл тогтнож байжээ), XIX зууны 60-70-аад оны дунганы бослого, Монголчуудын дугуйлангийн хөдөлгөөн зэргийг дурдаж болно. 1911 онд Гадаад монголд монголын ард түмэн манж хятадын ноёрхлыг устгаж, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн нь ардын хувьсгалын ялалтаар 1921 онд дуусаж БНМАУ-ыг тунхагласан билээ. Синь-зяны хятад биш ард түмний тэмцлээр 1944 онд Дорнод туркестаны БНУ байгуулагдаж байсан юм.

Гэтэл одоогийн маоист түүхчид хятад улсыг анхнаасаа «нэгдмэл олон үндэстний улс» байсан мэтээр түүхийг ичгүүр сонжуургүй гуйвуулж байна.

Маоистуудын хятад биш ард түмнүүдийн түүхийг гуйвуулж байгаагийн нэг жишээ нь бүр эрт дээр үеэс хятад бол «олон үндэстний нэгдсэн улс» байсан ийм учраас Төвд, Өвөр Монгол, Синьзян гэх мэт хятад биш ард түмний нутаг нь хятадын нутаг юм. Энэхүү хуурамч сэдвийн дагуу маоистууд хятадад амьдарч байгаа бүх ард түмнүүд хан үндэстний эвгээлд багтсан «чжунхуа минзү» буюу нэг үндэстэн гэж батлахыг оролдож байна. 1978 оны III сард Бээжинд хятад биш ард түмний асуултанд зориулсан бүх хятадын бага хурал дээр Хятад оронд ганц л үндэстэн байгаа бөгөөд тэр нь «хятад» үндэстэн, бусад хан бус ард түмэн нь хятад үндэстний бүрэлдэхүүн хэсэг гэж тогтоожээ.<sup>11</sup> Шинжлэх ухааны эсрэг их гүрний дээрэнгүй энэ «онол» Чан Кайшийн «хятадын хувь заяа» гэсэн номондоо чалчидаг «хятадын нэгдмэл үндэстэн» хоорондоо «ах дүүгийн холбоотой гэсэн «онолтой» нийцэж байна.

Чан Кайши уул номондоо «Манай их хятад үндэстэн олон аймгуудын нийлбэр дээр байгуулагдсан юм. Энэ аймгууд нэг угсаатны гаралтай бөгөөд сүүлийн 5 мянган жилийн дотор хоорондоо нэгдэж нэг үндэстэн болсон юм. Ингэж нэгдэхийн хүчин зүйл нь зэвсгийн хүчин биш харин соёлын (хятадын) хүч байсан юм» гэнэ. «Нэгдсэн нэгдмэл хятад үндэстэн», «хятад төвийн гэсэн «онолд» тулгуурласан хятадын их гүрний дээрэнгүй бодлогыг хамгаалахын тул маоистууд хятад биш ард түмний түүх, хятад улсын олон үндэстний улс байгуулагдсан түүхийг гуйвуулж байна. Их гүрний дээрэнгүй бодлогын тодорхой нэг жишээ нь Ши Юнсиний бичсэн өгүүлэлд<sup>12</sup> харагдаж байна гэж С. Л. Тихвинский анхааруулсан юм. Ши Юнсиний энэ өгүүлэлд Хятадын 2000 жилийн түүх нь хятадын боол, феодалын эзэн хаадын 2000 жилийн түүхэнд хятадын цэргүүдийн хөл тавьсан газар бүр БНХАУ-ын нутаг дэвсгэрийн бүрэлдэхүүнд орох ёстой ажээ. Өөрөөр хэлбэл «Миний морь гишгисэн газар бол миний газар» гэсэн феодалын зарчим энэ санаанд харагдаж байна. Энэ зарчмыг баримтлах юм бол түүхийн зарим нэг үед хан улс (мээ 206 мээ 220) Тан улс (618-907) Монголын Юан (1280-1368) Манж Чин (1644-1911) улсуудын захиргаанд хүчээр орж байсан Ази тивийн үндэстнүүд одоогийн байдлаар хятад үндэстний тоонд тоологдох болоод

<sup>10</sup>Думан Л. И. Завоевание Цинской империей Джунгарий и Восточного Туркетана В. сб: Маньчжурское владычество в Китае. М. 1966 с 268

<sup>11</sup>«Гуань минь жибао», 1978. III. 16.

<sup>12</sup>Лиши яньцзю (түүхийн судлал) 1974.г № 1.

байна.<sup>13</sup> Энэ бүхэн нь ямар ч учир утгагүйн талаар С. Л. Тихвинский цааш нь бичихдээ: түүхийн хөгжлийн зарчмыг баримтлахгүй маиоистуудын зарчим баримталбал дээр үеийн Дари, Македон Александр, Юли Цезарь, Чингис хаан, Их Могол, Осман, Габсбург зэрэг эзэн хаант улсуудыг түүний хуучин хил хязгаартай нь сэргээх болж байна. Тэгээд дээр үед тэдгээр эзэн хаант улсуудын нутаг дээр амьдарч байсан үндэстэн ястан ард түмнийг хүчээр одоогийн иран, грек, итали, монгол, узбек, түрк, австричууд гэж нэрлэхэд хүрэх юм гэжээ.

Маоистууд хятад биш ард түмний түүхийг гуйвуулж байгааг хүннү нарын түүхээс харж болно. Маоист түүхч Цзинь Фанизянь бичихдээ: хятадыг Цин Шихуан<sup>14</sup> нэгтгэхээс өмнө хүннү нь хятадын хуучин үндэстний нэг нь байсан юм. Хүннү нар хятадууд болон бусад хятад биш ард түмэнтэй нягт холбоотой байв. У Ди<sup>15</sup> дайнд хүннүг ялсан явдал хятадын олон үндэстнийг нэгтгэхэд маш их ашигтай болсон, энэ дайн бол «гадаадын түрэмгийллийн эсэргүүцэл биш юм» гэжээ.

Маоистууд уйгарын биеэ даасан түүхийг үгүйсгэж уйгар, уйгарын эртний нутгийг хятадынх гэж үзэж байна.

Хятадын өөр нэгэн маоист түүхч Хан Жулинь Чингис хааны тухай өгүүлэлдээ: «Дэлхий дахинд мандсан Чингис хаан гарч түүний цэргийн морь 45 том бага улс орнуудын төмөр ханыг цөмрөн орж, энэ орнуудын ард түмнийг өндөр соёлтой танилцуулж, түүнээс сурах бололцоо олгож нүдийг нь нээсэн юм. Иймд түүхэн хөгжлийн үүднээс үзэхэд Чингис хааны ролийг үгүйсгэж болох уу?» гэжээ<sup>16</sup>

Хятадын бусад хятад биш ард түмэнтэй адилхан дарлагдаж байгаа өвөр монголын ард түмнийг «өөрийнхөө талд» оруулахын тулд хятадын эрх баригчид Чингис хааны нэрийг ашиглаж байна гэж хөрөнгөтний хэвлэлд хүртэл бичигдсэн байна. Бас өөр нэг шалтгаан бий. Чингис хааны удмууд 100 гаруй жил хятадыг зээлж байсныг «хуулийн үндэс»-тэй бол-гож, Бээжингийнхэн монгол хаадуудын эзэлж байсан газрыг өөрийнх гэж үзэж байна. Ийм учраас түүхийг дахин судлах явдал хятадын эрх баригчдад маш их ач холбогдолтой болжээ. М. И. Сладковский маоист түүхчдийн гол зорилт нь «бусад ард түмний түүхэн амжилтыг багасгаж, хятадад амьдарч байгаа хятад биш ард түмнийг үндэстний түүхгүй болгож, бүгдийг «нэгдсэн хятад үндэстэн»-д хамааруулж, үүний үндсэн дээр их гүрний дээрэнгүй бодлогыг түүх онолын үндэслэлтэй болгох гэж оролдож»<sup>17</sup> байна гэж бичжээ.

Орос хэлнээс товчлон орчуулсан  
**А. Дамдинсүрэн.**

<sup>13</sup>Тихвинский С. Л. Борьба с апологетикой великоханьского гегемонизма-Важная задача исторической науки. в сб: Актуальные проблемы борьбы с маоистскими фальсификациями в области истории. с 96.

<sup>14</sup>Цинь Шихуан-первый циньский император, правивший в 246-210 гг До н.э.

<sup>15</sup>У Ди-ханьский император, правивший в 140—87 гг. До н. э.

<sup>16</sup> «Лиши Яньцзю» 1962, № 3.

<sup>17</sup>Сладковский М. И. Основные аспекты маоистской фальсификаций историй— В сб: Актуальные проблемы борьбы с маоистскими фальсификациями в области истории, с 6.